



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 06 дугаар сарын 09 өдөр Дугаар 38

Хэрлэн сум

XXXVII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 38 дугаар хурал 2020 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн 09:30 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1.Тэсэрч, дэлбэрэх бодис илрүүлэх, хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулсан тухай танилцуулах:

*Тагнуулын газрын мэргэжилтэн, хурандаа Б.Чинбат*

2.Хүчтэй салхины улмаас Хэрлэн сумын 1 дүгээр багийн 28 дугаар байрны дээвэр хууларсан асуудлыг хэлэлцэх:

*Хэрлэн сумын Засаг даргын орлогч О.Пүрэв-Очир*

3."Петрочайна Дачин Тамсаг" компаниас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийг хэлэлцэх:

*Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа*

4.Дорнод аймагт үйл ажиллагаа явуулдаг амралтын газруудаас ирүүлсэн санал хэлэлцэх:

*Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа*

5.Улсын Онцгой комисст аймгийн Онцгой комиссоос хүргүүлсэн албан бичгийн хариуг танилцуулах:

*Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат*

6.Рестораны ажиллах цагийн хуваарийг сунгах эсэх талаар хэлэлцэх:

*Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат*

7.Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн зарцуулалт, саналыг танилцуулах:

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын  
дарга, хурандаа Г.Нармандах

8.Спорт заалыг нээх эсэх талаар хэлэлцэх:

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын  
орлогч дарга Ч.Ганбат-д:

1.1.Тэсэрч, дэлбэрэх бодис илрүүлэх хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулахад оролцсон албан хаагч нарт урамшуулал олгох,

1.2. Тэсэрч, дэлбэрэх бодисоос урьдчилан сэргийлэх самбарын зардлын төсвийг тус тус аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг,

Хоёр. АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн  
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа нарт,

2.1.Хүчтэй салхины улмаас Хэрлэн сумын 1 дүгээр багийн 28 дугаар байрны дээвэр хууларсантай холбогдуулан барилга ашиглалтын болон хохиролын үнэлгээ тогтоох мэргэжлийн албан хаагч нарыг томилж ажиллуулахыг,

2.2.Хэрлэн сумын 6, 7 дугаар багийн төмөр дээвэртэй 8, 10, 46 дугаар байруудын дээврийн аюулгүй байдалд хяналт шалгалтыг зохион байгуулж аймгийн Онцгой комиссын 39 дүгээр хуралдаанд танилцуулахыг,

Гурав. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа нарт,

3.1.Хилийн Баянхошуу боомтод короновируст халдварын эрсдлийн үнэлгээ хийсэн тухай мэдээлэл, Мэргэжлийн хяналтын байгууллагын мэдээллийг нэгтгэж аймгийн Онцгой комиссын 39 дүгээр хуралдаанд танилцуулахыг,

Дөрөв.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа,  
Стандартчилал, хэмжил зүйн хэлтэсийн  
дарга Н.Энхболд нарт:

4.1.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 167 дугаар тогтоолыг үндэслэн Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газраас тавигдсан стандарт шаардлагыг хангасан сумын Засаг даргаас олгосон зохих зөвшөөрөлтэй газар эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн жуулчны бааз, амралт сувилалын үйлчилгээний газруудыг 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс тусгай журам тогтоон мөрдүүлж, үйл ажиллагааг хэвийн явуулахыг зөвшөөрөв,

Сүмдын Засаг дарга нарт:

4.2. Жуулчны бааз, амралт, сувиллын үйлчилгээний газруудын үйл ажиллагааг эхлүүлсэнтэй холбогдуулан БОАЖЯ-наас гаргасан зөвлөмж, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газрын хамтран баталсан тусгай журмыг газар нутгийн хэмжээнд мөрдөж, хяналт тавьж ажиллахыг,

Мэргэжлийн хяналтын газар,

Эрүүл мэндийн газар,

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар,

Байгаль орчин аялал жуулчлалын газар,

Булган сумын Засаг дарга,

"Нийтийн аж ахуй" ОНӨААТҮГ-ын дарга нарт.

4.3. Удирдамжийн дагуу "Ухаа арал" амралтын газрын асуудалтай холбоотой газар дээр нь ажиллан мэдээллийг нэгтгэж аймгийн Онцгой комиссын 2020 оны 39 дүгээр хуралд танилцуулахыг,

Тав. АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,

Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,

5.1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 102 дугаар тогтоолын 3 дахь хавсралтын дагуу ОХУ-аас ирэх Монгол улсын иргэдийг Алтанбулаг боомтоор татан авахаар шийдвэрлэсэн. Иймд ОХУ-ын Өвөр байгалийн хязгаарын Чита хот, Агын районд байгаа Монгол улсын иргэдэд гадаад харилцааны шугамаар мэдэгдэхийг,

Зургаа. Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,

цагдаагийн хурандаа Т.Ганзориг

6.1. Ресторан, кафены ажиллах цагийн хуваарийг 00:00 цаг хүртэл сунгахыг,

6.2. Бүх төрлийн худалдаа үйлчилгээ үзүүлдэг аж ахуй нэгжүүдийн ажиллах цагийн хуваарийг 22:00 цаг хүртэл хэвээр үргэлжлүүлэхийг,

Долоо. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой

комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-т:

7.1. 2020 оны 06 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд хилийн Баянхошуу боомтод эрсдлийн үнэлгээ хийсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүний 5 албан хаагчийн томилолтын зардал 216,000 төгрөг, шатахууны зардал 285,000 төгрөг, нийт 501,000 төгрөгийг зардлыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Эрүүл мэндийн газарт олгохыг,

7.2. Аймгийн Онцгой комисс, Шуурхай штабын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай 4 нэр төрлийн техник хэрэгслийг худалдан авах 2,980,000 төгрөгийн зардлыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгохыг,

Найм.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтүяа,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Биеийн тамир спортын газрын дарга Б.Чимэддорж,  
Аймгийн Музейн захирал Н.Энхбаяр нарт:

8.1.Аймгийн Спортын ордон, Хэрлэн Номин бизнес төвийн спорт заал, Хэрлэн сумын 2 дугаар багийн спорт заал, "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн спорт заал, "Дорнод дээд" сургуулийн спорт заал, "Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төв"-ийн спорт заал, "Хүний хөгжлийн ордон"-ын спорт заал, "Политехникийн коллеж"-ийн спорт заалын үйл ажиллагааг нээхийг,

8.2.Спорт заалын үйл ажиллагааг эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан 10:00-аас 22:00 цаг хүртэлх хугацаанд иргэдэд үйлчлэх,

8.3.Спорт зааланд Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газрын дарга нарын хамтран тушаалаар баталсан журмыг баримталж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг,

8.4.Аймгийн музей, Ялалт музейн үйл ажиллагааг эхлүүлж эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг баримталж, нэг дор 10-аас дээшгүй иргэдэд үйлчилгээг үзүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА



М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.БАТТУЛГА